



# Есүс бидэнд тайтгарлыг амласан

Есүс Христ Өөрийг нь нас барсны дараа шавь нарт нь тайтгарал хэрэгтэй болохыг мэдэж байсан учраас тэдэнд Ариун Сүнсний тухай заасан юм. Тэр Ариун Сүнс тэдэнтэй үргэлж хамт байж, тайтгаруулах болно хэмээн амласан. Ариун Сүнсний өөр нэг нэр бол Тайтгаруулагч. Биднийг гунигтай эсвэл айдастай үед Ариун Сүнс бидэнд Есүс Христийн хайрыг санахад тусалдаг. ●

Энэ түүхийн талаар Иохан 14:1, 16-18, 26-аас уншиж болно.

## БИ БУСДЫГ ТАЙТГАРУУЛЖ ЧАДНА

Хэнд тайтгарал хэрэгтэй байна вэ?

Залбирч, тэдэнд туслах төлөвлөгөө гарга.

Төлөвлөгөөнийхөө дагуу үйлд!



Би аав, ээж хоёртойгоо хүүхдийн эмнэлэгт хөнжил хандивласан. Хөнжил нь хүүхдүүдийг айхгүй байхад туслах болно гэж эмнэлгийн ажилтнууд хэлсэн. Бидний өгсөн хөнжил хүүхдүүдийг тайтгаруулж, баярлуулна гэдгийг сонсох надад сайхан санагдсан. Энэ нь намайг ч гэсэн баярлуулсан.

**9 настай Бруклин Д., АНУ-ын Техас муж**

Чи хэрхэн Есүстэй адил бусдад туслахыг хичээж байгаа вэ? Бидэнд хандан бичиж бас ярьж өгөөрэй.

